

**ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ ХК-ИЙН 2020 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН /хураангуй/**

*/Хугацаа: 2020 оны 01 дүгээр сарын 01-ний
өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр/*

Улаанбаатар хот
2020 он

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Оршил

Үндэсний давхар даатгал ХК нь 2020 онд үйл ажиллагаандаа Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан компанийн Бизнес төлөвлөгөө, Гүйцэтгэх захирлын 2020 оны А/05 дугаар тушаалаар батлагдсан компанийн 2020 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг тус тус удирдлага болгон ажиллалаа.

ХОЁР. ДАВХАР ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД

2.1. Компанийн давхар даатгалын үйл ажиллагааг зохион байгуулж, хөдөө аж ахуйн болон бусад даатгалын бүтээгдэхүүний давхар даатгах эрсдэлийн судалгаа, андеррайтинг хийж, үнийн санал боловсруулах

Малын индексжүүлсэн даатгал /МИД/

Ард даатгал ХК, Бодь даатгал ХК, Миг даатгал ХХК, Монгол даатгал ХК, Монре даатгал ХХК, Мөнх даатгал ХХК, Номин даатгал ХХК, Практикал даатгал ХХК, Тэнгэр даатгал ХХК, Хаан даатгал ХХК гэсэн 10 даатгалын компани болон ХААН банк, Төрийн банкуудтай хамтран МИД-ын 2020 оны борлуулалтыг 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлүүлэн, зуучлагч 2 банкны борлуулалт бүртгэх эрхийг 6 дугаар сарын 30-ны өдрөөр, оролцогч даатгалын компаниудын борлуулалт бүртгэх эрхийг 7 дугаар сарын 15-ны өдрөөр тус тус хаасан.

Тайлант онд МИД-д **28,527** малчин өрх, 99,868,378,481.89 /ерэн есөн тэрбум найман зуун жаран найман сая гурван зуун далан найман мянга дөрвөн зуун наян нэгэн төгрөг наян есөн мөнгө/ төгрөгийн үнэлгээ бүхий 7,109,443 толгой малаа даатгуулж, нийт **3,478,513,328.02 /гурван тэрбум дөрвөн зуун далан найман сая таван зуун арван гурван мянга гурван зуун хорин найман төгрөг хоёр мөнгө/** төгрөгийн хураамжийн орлогыг төвлөрүүлсэн.

МИД-ын 2020 оны борлуулалтад оролцсон 10 даатгалын компанитай 2019 оны 12 дугаар сарын 19-ний өдөр “Алдагдал зогсоох давхар даатгалын гэрээ” байгуулж, давхар даатгалын хураамжид 1,108,271,263.97 /нэг тэрбум нэг зуун найман сая хоёр зуун далан нэгэн мянга хоёр зуун жаран гурван төгрөг ерэн долоон мөнгө/ төгрөгийг нэхэмжлэн компанийн дансанд төвлөрүүлсэн.

Тариалангийн индексжүүлсэн даатгал:

Хөдөө аж ахуйг дэмжих сан /Сан/-ийн хүсэлтээр 2020 оны 3 дугаар сарын 30-ны өдөр тус Сантай улаан буудайн тариалалт эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдийг даатгалд хамруулах талаар уулзалт зохион байгууллаа. Уулзалтаар Сангаас зээл авч буй бүх тариалан эрхлэгчдийг даатгалд хамруулахаар болж, улаан буудайн индексжүүлсэн даатгалыг хэрэгжүүлэхээр харилцан тохиролцож, улаан буудайн индексжүүлсэн даатгалд “Хамтран ажиллах гэрээ”-г 6 дугаар сарын 02-ны өдөр байгуулсан. Гэрээний хүрээнд улаан буудайн индексжүүлсэн даатгалд даатгуулсан аж ахуйн нэгжүүдийн мэдээлэл, хохирол үнэлгээ болон нөхөн төлбөрийн мэдээллийг тухай бүр Санд хүргүүлж байсан.

Улаан буудайн индексжүүлсэн даатгалын загварчлалыг боловсруулах зорилгоор Холбооны Бүгд Найрамдах Герман Улс /ХБНГУ/-ын “Лайбницийн нэрэмжит Шилжилтийн эдийн засагтай орнуудын хөдөө аж ахуйн хөгжлийн хүрээлэн” /Хүрээлэн/-тэй “Хамтран ажиллах гэрээ”-г 4 дүгээр сарын 14-ний өдөр байгуулсан. Тус Хүрээлэн нь ургамлын ургалтын ногоорлын индекс /NDVI/-ийг хиймэл дагуулаас авч, 2020 оны улаан буудайн

индексжүүлсэн даатгалд хамрагдсан тариалан эрхлэгчдэд олгох нөхөн төлбөрийн тооцооллыг хийсэн. Хүрээлэн нь хөдөө аж ахуй, хүнсний салбарт гарсан эдийн засаг, нийгэм, улс төрийн өөрчлөлтийн процесст анализ хийж, Европын холбоо, Төв, Зүүн болон Зүүн Өмнөд Европ, Төв болон Зүүн Азийн шилжилтийн эдийн засагтай орнуудад голчлон төвлөрч ажилладаг. Хүрээлэнтэй хамтран улаан буудайн индексжүүлсэн даатгалын хураамжийг тооцоолох, нөхөн төлбөрийн аргачлалыг гаргах, даатгуулагчтай байгуулах гэрээний төслийг боловсруулах, 2021 онд хэрэгжүүлэх бүтээгдэхүүнээ улам хөгжүүлэх тал дээр хамтран ажиллаж байна.

Газар тариалангийн даатгалын бүтээгдэхүүн:

Ард даатгал ХК болон Мөнх даатгал ХХК-уудтай 2020 оны борлуулалтын улиралд хамтран ажиллахаар болж, 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 20-ны өдөр хүртэл улаан буудайн индексжүүлсэн даатгалыг амжилттай хэрэгжүүллээ. Тайлант хугацаанд нийт 387 аж ахуйн нэгжийн 15.1 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий 22.5 мянган га талбайг даатгаж, 539.0 сая төгрөгийн даатгалын хураамжийн орлогыг төвлөрүүлэх гэрээг байгуулсан. Үүнээс 90 хувь буюу 13.5 тэрбум төгрөгийн хариуцлагыг давхар даатгах “Хөдөө аж ахуйн хувь оролцооны давхар даатгалын гэрээ”-г 2020 оны 6 дугаар сарын 15-ны өдөр Ард даатгал ХК, Мөнх даатгал ХХК-тай байгуулж, 485.0 сая төгрөгийн даатгалын хураамжийг төвлөрүүлэхээр боллоо.

2.2. Давхар даатгалын гэрээ болон баталгааг даатгалын компаниудтай байгуулах, даатгалын компаниуд, зуучлагч банкууд болон бусад оролцогч талуудтай хамтарч ажиллах

МИД-ын борлуулалтын сургалт, сурталчилгаа:

Монгол Улсын хэмжээнд орон нутагт албан томилолтоор ажиллах, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахыг хориглосон байгаа учраас олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан малчдад мэдээлэл хүргэх, сурталчлан таниулах ажлыг хийлээ. Даатгагчдын хамтарсан хурлаар олон нийтэд МИД-ыг сурталчлан таниулах зорилготой МИД-ын 3 минутын сурталчилгаа хийлгэх шийдвэр гарсны дагуу сурталчилгааг Рояал Пик ХХК-тай “Хамтран ажиллах гэрээ” байгуулан хийлгэсэн. Тус сурталчилгааг 5 дугаар сарын 27-ны өдрөөс 6 дугаар сарын 30-ны өдрийг дуустал хугацаанд өдөр бүр 5 удаагийн давталттайгаар Малчин телевиз болон Үндэсний давхар даатгал ХК-ийн сошиал хуудсанд тус тус байршуулж олон нийтэд хүргэсэн.

МИД-ын борлуулалтыг идэвхжүүлэх, мөн малчдын МИД-ын талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор 15 минутын хугацаатай нэвтрүүлгийг Малчин телевизтэй хамтран бэлтгэж, сард 2 удаагийн цацалтаар олон нийтэд мэдээлсэн.

МИД-ын гарын авлага болон тараах материалыг шинэчлэн засаж гарын авлага 10,000 ширхэг, тараах материал 20,000 ширхгийг тус тус хэвлүүлэн даатгалын компаниудад хуваарилан тараасан.

МИД-ын үйл ажиллагааг идэвхжүүлэх, түүний ач тусыг малчдад сурталчлан таниулах, борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор орон нутагт хөлсөөр ажиллах гэрээгээр ажилтнуудыг ажиллуулсан. Эдгээр ажилтнууд сар бүр хийсэн ажлынхаа тайланг ирүүлж, дүгнүүлэн ажиллалаа.

Долоо хоног бүр МИД-ын борлуулалтын явцын мэдээг Захирлын зөвлөлийн хуралд тайлагнаж, гарсан шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан.

Оролцогч даатгагчдын төлөөлөгч нар, малчид, сум орон нутгийн холбогдох мэргэжилтнүүдэд 98070770 нээлттэй утсаар дамжуулан МИД болон компанийн бусад бүтээгдэхүүний талаар тайлант онд заавар зөвлөгөө өгөн ажиллалаа.

2020 оны 4 дүгээр сарын 28, 6 дугаар сарын 10-ны өдрүүдэд Монголын даатгалын зуучлагчдын холбооноос даатгалын мэргэжилтнүүдэд зориулан зохион байгуулсан онлайн сургалтад Ахлах андеррайтер МИД-ын талаар цахим хичээл орлоо.

МИД-д оролцогч даатгалын компаниудтай нийт 8 удаагийн хуралдаан хийсэн ба хуралдаанаас хэрэгжүүлсэн ажлуудыг дурдвал:

- МИД-ын борлуулалтын талаар “Алдагдал зогсоох давхар даатгалын гэрээ”-ний дагуу оролцогч даатгалын компаниудад мэдээлэл өгөх сургалт зохион байгуулж, “МИД-ын борлуулалтын журам”-ын дагуу борлуулалтыг хааж, дуусгасан.
- МИД-ын борлуулалтын хаалтыг хугацаандаа амжиж бүртгэж чадаагүй асуудлаас үүдэлтэй 2021 оны МИД-ын “Алдагдал зогсоох давхар даатгалын гэрээ”-нд даатгагчдад тавигдах шаардлагыг нэмэгдүүлэх талаар арга хэмжээ авч ажиллахаар даатгагчдын хамтарсан хурлын 2020-05 дугаар тогтоолоор шийдвэрлэлээ.
- МИД-ын 2019 оны нөхөн төлбөрийг олгох болон даатгалын сургалт хийхээр 2020 оны 9 дүгээр сарын 20-ны өдрөөс 27-ны өдрийг хүртэлх хугацаанд Хөвсгөл, Архангай аймгийн нийт 6 суманд даатгалын компаниудтай хамтран андеррайтерууд томилолтоор ажиллалаа.
- Цаашид МИД-ыг цахимаар борлуулах ажлыг судлах, хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулагдсаны дагуу МИД-ын борлуулалтыг цахимаар борлуулах платформ боловсруулах зөвлөх сонгон шалгаруулах зарыг компанийн цахим хуудсанд байршуулж, шалгарсан компани болох Гэрэгэ Системс ХХК-тай 2020 оны 4 дүгээр сарын 07-ны өдөр гэрээ байгуулсан. Гэрээний дагуу Үндэсний дата төвөөс малын тоон мэдээг авах эрхийг нээлгэн, холболтуудыг хийлгэж МИД-ыг киоск машинаар борлуулах платформыг ашиглахад бэлэн болгосон. Уг ажлын талаар оролцогч даатгалын компаниудын саналыг аван 2021 оноос хамтран ажиллахаар боллоо.

Газар тариалангийн даатгалын сургалт, сурталчилгаа:

Тариалан эрхлэгчид болон хамтран ажиллаж буй байгууллагуудад мэдээлэл хүргэх зорилгоор даатгалын шинэ бүтээгдэхүүн болох Улаан буудайн индексжүүлсэн даатгалын нэвтрүүлгийг /15 мин/ Роял Пик ХХК-тай хамтран бэлтгэлээ. Бэлэн болсон нэвтрүүлгийг хүлээн авч, Үндэсний давхар даатгал ХК болон Хөдөө аж ахуйг дэмжих сангийн цахим хуудаснуудад байршуулсан.

Улаан буудайн индексжүүлсэн даатгалын тухай мэдээллийг хамтран ажиллагч Ард даатгал ХК, Мөнх даатгал ХХК-ийн даатгалын төлөөлөгч болон бусад холбогдох албан тушаалтнуудад хүргэх зорилгоор онлайн хичээл бэлтгэж хүргүүлсэн.

Оролцогч талуудын хамтын ажиллагаа:

Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Засгийн газрын бүрэлдэхүүн хэсэг болох Английн сансрын агентлагийн санхүүжилттэй “Сибэлиус” төсөлтэй байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ний дагуу шаардлагатай мэдээллийг бэлтгэн хүргүүлж байна. Тус төсөл нь цаг уурын үзүүлэлтүүдэд тулгуурлан малын хохирлыг тооцоолж, МИД-ын шинэ хэлбэрийг нэвтрүүлэх зорилготой юм.

Дотоодын даатгалын зах зээлд уул уурхайн эрсдэлийг давхар даатгах үйлчилгээг зах зээлийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан нэвтрүүлэх ажлын хүрээнд Практикал даатгал ХХК-тай анхны уул уурхайн давхар даатгалын ерөнхий гэрээг 2020 оны 3 дугаар сарын 09-ний өдөр байгууллаа. Тус гэрээг байгуулснаар Практикал даатгал ХХК-д тоног төхөөрөмж, машин механизм, хариуцлагаа даатгуулсан уул уурхайн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүд бүх төрлийн эрсдэлүүдээс бүрэн хамгаалагдах боломжтой юм. Дээрх үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах ажлын хүрээнд NTV, MN25 телевиз, олон

нийтийн цахим сүлжээ болон Засгийн газрын мэдээ сонинд хэвлүүлж, олон нийтэд мэдээллээ.

Ди Би Эм Лизинг ХХК-ийн санхүүгийн түрээсээр түрээслүүлж буй техник, тоног төхөөрөмжид хөрөнгийн даатгалын үйлчилгээ үзүүлэх зорилгоор Ди Би Эм Лизинг ХХК-ийн холбогдох мэргэжилтнүүдтэй 2020 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр уулзлаа. Уулзалтаар “Харилцан ойлголцол, хамтын ажиллагааны санамж бичиг” байгуулах нь зүйтэй гэж үзэж 2020 оны 3 дугаар сарын 01-ний өдөр санамж бичиг байгуулсан.

ХХААХҮЯ-аас Тариалангийн даатгалын тухай хуулийн үзэл баримтлал, хуулийн төслийг яаравчлуулах зорилгоор зөвлөх гэрээлэн авч ажиллах болсон бөгөөд 2020 оны 3 дугаар сарын 27-ны өдөр яамны холбогдох мэргэжилтэн болон зөвлөхтэй уулзаж, хуулийн төслийн эхний хувилбарыг боловсруулахад саналаа өглөө. Мөн хуулийн төсөлтэй холбоотой эдийн засгийн тооцооллыг эхний байдлаар боловсруулж, танилцуулсан. ХХААХҮЯ-аас хуулийн төсөлд санал авахаар оролцогч талууд болох Сан, даатгалын компаниуд руу явуулж саналуудыг нэгтгэн хэлэлцүүлэг хийхээр хүлээж байна.

Дотоодын даатгагчдын Трити /багцын/ давхар даатгалын гэрээний хугацааг судалж, хугацаа нь дуусаж буй даатгагчдад Трити давхар даатгалын гэрээ байгуулах, хамтран ажиллах санал тавин холбогдох танилцуулга, сургалтыг зохион байгуулан ажиллалаа. Монгол даатгал ХК, Монре даатгал ХХК-уудад холбогдох мэдээллийг хүргүүлж, Амар даатгал ХХК, Хаан даатгал ХХК-уудтай уулзалт зохион байгуулж, танилцуулга хийсэн. Үр дүнд нь Монгол даатгал ХК-ийн Трити гэрээний 5 хувийг давхар даатгаж, Амар даатгал ХХК-ийн зарим даатгалын бүтээгдэхүүнүүдийг багцлан давхар даатгалын ерөнхий гэрээгээр давхар даатгалаа.

Хөрөнгийн даатгалын бүтээгдэхүүний давхар даатгалын гэрээ:

2020 оны 4 дүгээр улирлын байдлаар хөрөнгийн даатгалаар 776.1 тэрбум төгрөгийн үнэлгээг 960.0 сая төгрөгийн давхар даатгалын хураамжаар даатгах гэрээ болон баталгааг байгуулаад байна.

Ачаа тээврийн даатгалын бүтээгдэхүүний борлуулалт, давхар даатгалын гэрээ:

Ачаа тээврийн даатгалын бүтээгдэхүүний хувьд 4 дүгээр улирлын байдлаар нийт 3.7 тэрбум төгрөгийн үнэлгээг, 6.7 сая төгрөгийн давхар даатгалын хураамжаар даатгаад байна. Ачаа тээврийн даатгал нь ихэвчлэн трити давхар даатгалын гэрээгээр бусад бүтээгдэхүүнтэй багцлан орж ирсэн.

Хариуцлагын даатгалын бүтээгдэхүүний давхар даатгалын гэрээ:

Хариуцлагын даатгалын бүтээгдэхүүний хувьд 4 дүгээр улирлын байдлаар нийт 1,333.1 сая төгрөгийн хариуцлагыг давхар даатгаж, 521.7 сая төгрөгийн даатгалын хураамжийн гэрээ болон баталгааг байгуулаад байна.

Барилга угсралтын даатгалын бүтээгдэхүүний давхар даатгалын гэрээ:

Барилга угсралтын даатгалын бүтээгдэхүүнээр тайлант онд нийт 15.4 тэрбум төгрөгийн үнэлгээг 28.2 сая төгрөгийн давхар даатгалын хураамжаар, санхүүгийн даатгалаар нийт 19.1 тэрбум төгрөгийн үнэлгээг 38.5 сая төгрөгийн давхар даатгалын хураамжаар, гэнэтийн ослын даатгалаар нийт 4,377.4 /дөрвөн тэрбум гурван зуун далан долоон сая дөрвөн зуун мянган/ төгрөгийн үнэлгээг 42.6 сая төгрөгийн давхар даатгалын хураамжийг тус тус төвлөрүүлэв.

Агаарын хөлгийн даатгалын бүтээгдэхүүний давхар даатгалын гэрээ:

Агаарын хөлгийн даатгалаар тайлант онд 12.1 тэрбум төгрөгийн үнэлгээг 122.9 сая төгрөгийн давхар даатгалын хураамжаар, агаарын хөлгийн хариуцлагын даатгалаар нийт

10.1 тэрбум төгрөгийн үнэлгээг 67.9 сая төгрөгийн давхар даатгалын хураамжаар даатгалаа.

2.3. Олон улсын давхар даатгалын үйл ажиллагааг зохион байгуулж, олон улсын давхар даатгалын гэрээ болон баталгааг байгуулах

МИД-ын талаар олон улсын давхар даатгагчтай хамтын ажиллагаа:

МИД-ын 2020 оны борлуулалтад оролцож буй даатгагч нарын борлуулалтын төлөвлөгөө, компанийн давхар даатгалын төлөвлөгөөнд үндэслэн олон улсын давхар даатгагчдад тодорхой хэмжээний эрсдэлээ шилжүүлэх зорилгоор өнгөрсөн жилүүдэд МИД-ыг давхар даатгуулж байсан СКОР /SCOR/, Ханновэр Рэ /HannoverRe/, Катар Рэ /QatarRe/ болон бусад давхар даатгагч, брокеруудаас үнийн санал авахаар мэдээлэл бэлтгэж хүргүүлсэн. Олон улсын давхар даатгагч СКОР /SCOR/ компанийн зүгээс үнийн санал ирүүлж давхар даатгах хүсэлтээ ирүүлсэн ба Свисс Рэ /SwissRe/ компанийн хувьд дагаж орох хүсэлтээ ирүүлсэн. Дээрх саналуудыг компанийн Эрсдэлийн хороонд танилцуулж, 2020 оны МИД-ын эрсдэлийн дээд болон дунд түвшний давхар даатгалын гэрээг СКОР /SCOR/ /тэргүүлэгч/ болон Свисс Рэ /дагалдагч/ компаниуд доорх эрсдэлийн хэмжээгээр даатгахаар шийдвэрлэж, гэрээг байгуулав.

Эрсдэлийн дүнд түвшин: Нийт хураамжийн 65 хувь давсан 125 хувь буюу 4,348,141,660.03 /дөрвөн тэрбум гурван зуун дөчин найман сая нэг зуун дөчин нэгэн мянга зургаан зуун жаран төгрөг гурван мөнгө/ төгрөгийн эрсдэлийг даатгуулахаар харилцан тохиролцлоо.

Эрсдэлийн дээд түвшин: Нийт даатгалын үнэлгээний 0.3 хувь давсан 2.9 хувь буюу 2,896,182,975.97 /хоёр тэрбум найман зуун ерэн зургаан сая нэг зуун наян хоёр мянга есөн зуун далан таван төгрөг ерэн долоон мөнгө/ төгрөгийн эрсдэлийг даатгуулахаар харилцан тохиролцсон.

2.4. Давхар даатгалын үйл ажиллагааны журам болон бусад журмыг мөрдлөг болгон ажиллах

Үндэсний давхар даатгал ХК-ийн давхар даатгалын үйл ажиллагаа явуулах, андеррайтинг хийх, давхар даатгалын гэрээ, баталгааны төсөл боловсруулах, хянах, гэрээ байгуулах, баталгаа гаргахтай холбогдсон бүх харилцааг зохицуулсан “Андеррайтингийн журам”-ыг хамтран боловсруулж, Гүйцэтгэх захирлын 2020 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн А/24 дүгээр тушаалаар батлуулсан.

Улаан буудайн индексжүүлсэн даатгалын хүрээнд Хүрээлэнгээс 2020 оны 6,7 дугаар сарын ногоорлын индекс ирсэн бөгөөд нөхөн төлбөрийн тооцооллыг хийхэд туслалцаа үзүүллээ.

Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд Засгийн газар 3 жилдээ нэг удаа малын хорогдлын босго үзүүлэлтийг шинэчлэн тогтоохоор заасан байдаг бөгөөд үүний дагуу шинээр тогтоох босго үзүүлэлтийг тооцоолон Сангийн яаманд саналаа хүргүүлж, Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 219 дугаар тогтоолоор 2021-2023 онд ашиглах нэгдүгээр босго үзүүлэлтийн хувьд Дорнод, Дархан-Уул, Говьсүмбэр аймагт 5 хувь байсныг 6 хувь, Өмнөговь аймагт 6 хувь байсныг 5 хувь, хоёрдугаар босго үзүүлэлтийн хувьд Булган, Өвөрхангай, Төв аймгуудад 30 хувь байсныг 25 хувь, Орхон аймагт 25 хувь байсныг 30 хувь болгон өөрчилж, бусад аймгуудын босго үзүүлэлт хуучин хэвээр батлагдсан.

“Даатгалын багц дүрэм”-д заасны дагуу Үндэсний давхар даатгал ХК-ийн 2021 оны давхар даатгалын нарийвчилсан төлөвлөгөөг гаргаж 12 дугаар сарын 01-ний өдөр

Санхүүгийн зохицуулах хороонд цахимаар хүргүүлээ. Тус төлөвлөгөөнд компани 2021 онд 3.6 тэрбум төгрөгийн хураамжийн орлого олохоор төлөвлөсөн.

2.5. МИД болон давхар даатгалын бүтээгдэхүүний бүртгэл, эрсдэл тооцооллын програм хангамжийг боловсруулах, хэрэгжилтийг хангаж ажиллах.

Давхар даатгалын программ хангамжийг боловсруулах зорилгоор Фин тек сольюшнс ХХК-тай “Хамтран ажиллах гэрээ” байгуулж, программ хангамжийг боловсруулах ажлыг хийж гүйцэтгэлээ. Программ хангамжийг боловсруулах үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа бөгөөд шаардлагатай сайжруулалт, өөрчлөлтүүдийг цаг тухай бүр хийж байна. Дээрх программтай холбоотой гарсан асуудал, алдаа дутагдал бүрийг Фин тек сольюшнс ХХК-ийн ажилтантай хамтран тухай бүр нь засаж залруулж байна.

МИД-ын шинэ программд даатгалын компани, даатгалын төлөөлөгч, даатгалын компаниудын борлуулалт хийгдэх аймгуудын салбар, программд ажиллах хүмүүсийн эрхийн тохиргоо, тайлант онд харгалзах суурь мэдээллүүд, зуучлагч банкнуудын мэдээлэл, хураамж, малын үнэ гэх зэрэг хэрэгтэй мэдээллүүдийг оруулж 2020 оны борлуулалтыг эхлүүлсэн.

Даатгалын компани болон банкны хэрэглэгч нарт зориулсан гарын авлагыг хянаж боловсруулан программд байршуулсан.

2021 оны МИД-ын борлуулалтад Гэрэгэ киоск машин ашиглан малчдад даатгалыг илүү ойр хялбар байдлаар хүргэх шинэ борлуулалтын сувгийг нэмж, тестийн хувилбарыг туршин бэлэн болгоод байна. Тус киоск машинаар борлуулалт хийснээр төрийн мэдээллийн “Хур” системээс даатгуулагчийн харьяалал, малын тооны мэдээлэл зэргийг шалгаж борлуулалтын явцад гардаг түгээмэл алдаануудыг залруулах боломжтой болж байгаа юм.

ГУРАВ. ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА ХИЙЖ, ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ ГАРГАЖ ТУРШИХ АЖЛЫН ХҮРЭЭНД:

3.1. Даатгалын шинэ бүтээгдэхүүний загварыг гаргах

Тайлант хугацаанд зах зээлийн судалгаа хийж, шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх зорилгоор дараах дараах даатгалын бүтээгдэхүүний судалгааг хийлээ. Үүнд:

- Хүнд өвчний даатгалын бүтээгдэхүүн;
- Гүйцэтгэлийн баталгааны даатгалын бүтээгдэхүүн;
- Бизнес тасалдлын даатгалын бүтээгдэхүүн;
- Барилга угсралтын даатгалын бүтээгдэхүүн;
- Эмнэлгийн тоног төхөөрөмжийн даатгалын бүтээгдэхүүн;
- Аяллын даатгалын бүтээгдэхүүн;
- Гамшгийн даатгалын бүтээгдэхүүн;
- Экспортын даатгалын бүтээгдэхүүн;

3.2. Зах зээлийн болон эрсдэлийн судалгаа хийж, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ гаргаж турших ажлыг хийж хэрэгжүүлэх

Үндэсний давхар даатгал ХК нь өөрийн хариуцах эрсдэлийн тодорхой хувийг олон улсын давхар даатгалын компанид шилжүүлэх трити гэрээнд уул уурхайн эрсдэлийг шилжүүлэх боломжтой болсон тул Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа 56 томоохон ил уул уурхайн компаниудын жагсаалт гарган, хамтран ажиллах албан бичиг хүргүүлсэн. Монгол Улсын Засгийн газраас хөл хорио тогтоосонтой холбогдуулан уг албан бичгийг Уул уурхайн үндэсний ассоциацид хамтран цахим шуудангаар хүргүүлсэн.

Компанийн бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэх, хамтын ажиллагааг хөгжүүлэх хүрээнд МҮХАҮТ-ийн Платинум гишүүнээр элсэж, хамтран ажиллалаа. Танхимд гишүүнээр элссэнээр бизнесийн өмгөөллийн үйлчилгээ авах, аливаа бодлого боловсруулахад мэргэжлийн байр сууринаас санал бодлоо илэрхийлэх, судалгаанд хамрагдах, зөвлөгөө мэдээллийг цаг алдалгүй авах, танхимын мэдээллийн сувгуудаар өөрийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн үйлчилгээгээ сурталчлах давуу талтай. Гишүүнээр элссэн өдрөөс хойш шаардлагатай бизнес, эдийн засгийн судалгаануудыг цаг тухайд нь авч, цахим сургалтуудад хамрагдав.

Улаан буудайн индексжүүлсэн даатгалыг нэвтрүүлэх хүрээнд Хөдөө аж ахуйг дэмжих сантай байгуулах Хамтран ажиллах гэрээний төслийг боловсруулж, хамтран ажиллах гэрээ байгуулав.

Дотоодын даатгалын компаниудтай байгуулсан давхар даатгалын гэрээнүүдийн хэрэгжилтийг хангах ажиллалаа. Компанийн хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд 2019 онд байгуулсан хамтын ажиллагааны гэрээ дууссантай холбоотойгоор Бодь даатгал ХК, Номин даатгал ХХК, Амар даатгал ХХК, МИГ ХХК, Мандал ХК-тай хамтын ажиллагааны гэрээг сунгав. Тайлант оны хугацаанд Монгол даатгал ХК, Монре даатгал ХХК, Тэнгэр даатгал ХХК-уудтай хамтын ажиллагааны гэрээг шинээр байгууллаа.

Эдийн засгийн тэргүүлэх чиглэл, салбарыг тодорхойлон хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогыг боловсруулах, гадаад худалдааны бодлогыг зөв тодорхойлох, гадаадын хөрөнгө оруулагч нарт хөрөнгө оруулалтын төлөвлөлт хийхэд нь дэмжлэг үзүүлэх, идэвхжүүлэх, тэднийг хөхүүлэн дэмжих, хөрөнгө оруулалтыг тогтворжуулах асуудлыг судалж, шийдлийн санал боловсруулах, төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодлогыг зохистой төлөвлөж улсын эдийн засгийн чадавхыг дээшлүүлэх зорилгоор УИХ, Засгийн газар, Төрийн банк, Монгол дахь Америкийн Худалдааны танхим хамтран зохион байгуулсан Гадаад худалдаа, гадаад хөрөнгө оруулалтын форумд компаниа төлөөлөн оролцлоо. Уг хурлаар Гадаад хөрөнгө оруулалтын орчин, Олборлох салбарын орчин, Бизнесийн орчин зэрэг дэд сэдвүүдээр илтгэл тавьж, экспортыг хөгжүүлэх боломж, гарц, хамтын ажиллагааны уялдаа холбоог сайжруулах талаар хэлэлцүүлэг хийсэн.

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан МҮХАҮТ-аас Ковид-19 цар тахлын халдварыг хязгаарлах зорилгоор тогтоосон хатуу хөл хорионы дэглэм нь бизнесийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлж байгаа нөхцөл байдлыг үнэлэх, тулгарч буй хүндрэл, цаашид шаардлагатай дэмжлэгийг тодорхойлох санал асуулгад хамрагдав.

Олон улсын худалдаа ба инновацийн институцээс /Institute for Trade and Innovation/ олон улсын бага хурлыг жил бүр зохион байгуулдаг ба энэ жил Өөрчлөлтийн үе дэх эдийн засгийн хөгжил нэртэйгээр 9 дүгээр сарын 16-17-ны өдрүүдэд ХБНГУ-ын Оффенбургын их сургуулийн байранд болсон. Уг бага хуралд олон улсын экспортын зээлийн агентлагууд, экспортын санхүүжилт үзүүлдэг байгууллагуудаас төлөөлөл оролцдог бөгөөд энэ удаад цахимаар оролцлоо.

Ай Жи Кей /IGK зээлийн эрсдэлийн удирдлагын группээс зохион байгуулсан “БНХАУ дахь худалдан авагчийн зээлийн эрсдэл” сэдэвтэй нээлттэй вебинар /цахим хурал/-т оролцож, саад бэрхшээлүүдийн талаар мэдээлэл авсан.

Олон улсын давхар даатгагч Тай Ре компаниас зохион байгуулсан “Давхар даатгалын багц гэрээний бүтэц ба үнэ тогтоох” сэдэвт сургалтад 9 дүгээр сарын 30-ны өдрөөс 10 дугаар сарын 2-ны өдрийн хооронд онлайнгаар хамрагдлаа.

БНЭУ-ын Нектар эрсдэлийн институцээс зохион байгуулсан “Пропорционал бус трити гэрээний туршлага” сэдэвт сургалтад онлайнгаар хамрагдлаа. Тус сургалтаар пропорционал бус гэрээний төрлүүд, тус гэрээ бүрд хариуцлагын түвшин тогтоох арга, нөхцөлүүд,

бодолтууд болон олон улсын трити гэрээг хийхдээ ямар нөхцөлүүдийг анхаарах, тус нөхцөл бүрд ямар хариуцлага үүрч болох зэрэг мэдээлэл авсан.

3.3. Туршигдсан бүтээгдэхүүний зах зээлийг тэлэх, бүтээгдэхүүн үйлчилгээг сайжруулах ажлыг зохион байгуулах, давхар даатгалын бүтээгдэхүүний судалгаа шинжилгээ хийж, мэдээлэл боловсруулах

Хүнд өвчний даатгалын бүтээгдэхүүнийг Хонгконгийн олон улсын давхар даатгалын компани ПИК РЕ /PEAK RE/-тэй хамтран Монгол Улсын зах зээлд нэвтрүүлэхээр Хувь оролцооны /Quota share/ трити гэрээг 8 дугаар сарын 01-ний өдөр амжилтай байгуулсан.

Эмнэлгийн тоног төхөөрөмжийн даатгалын бүтээгдэхүүний судалгаа боловсруулан ажиллаж байна. Уг даатгалын бүтээгдэхүүн нь зөвхөн арилжааны зорилгоор ашиглагдаж буй тоног төхөөрөмжүүдийг даатгах боломжтой. Даатгалын гэрээний хамгаалалтын төрлүүдийн хувьд: хөрөнгийн хохирол буюу тоног төхөөрөмжийн гэмтэл болон хулгайн эрсдэл, хариуцлага, бүх төрлийн эрсдэлээс хамгаалах даатгалын хамгаалалтуудтай бүтээгдэхүүн юм.

Дэлхий нийтэд Ковид-19 цар тахлын тархалт эрчимжиж, гадаадад аялагчдад ихээхэн эрсдэл учирч байгаа тул даатгалын компаниудын аяллын даатгалын хамгаалалтууд даатгуулагчдын дунд эрэлттэй байгаатай холбогдуулан аяллын даатгалын бүтээгдэхүүний судалгааг боловсруулж, дотоодын даатгалын компаниудын хураамжийн тооцоолол, даатгалын гэрээний хасалтууд, хамгаалалтын талаар харьцуулан судалж, танилцуулга, даатгалын гэрээний загварыг боловсруулсан.

Гамшгийн эрсдэлийн даатгалын бүтээгдэхүүнийг судалж орчуулан танилцуулга бэлтгэв.

Улаан буудайн индексжүүлсэн даатгал нэвтрүүлэхэд хураамжийн тооцоололд шаардлагатай байсан тариалан эрхлэгчдийн нийт тариалах га талбай болон эргэлтийн талбайн мэдээллийг Булган аймгийн 13 сумын хөдөө аж ахуйн мэргэжилтнүүдтэй холбогдон 137 аж ахуйн нэгжийн мэдээллийг нэгтгэсэн.

Компанийн давхар даатгалын үйл ажиллагаанд баримтлах бодлогын хүрээнд холбогдох хууль журам, олон улсын жишигт нийцсэн давхар даатгалын гэрээний загвар боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт орж, иж бүрэн машин, тоног төхөөрөмжийн даатгалын гэрээг англи хэлээс монгол хэл рүү хөрвүүлэн, хянан тохиолдуулсан. Компанийн трити гэрээний хасалтын заалтын орчуулгыг хянан, сайжруулав. Олон улсын өнгөрөлтийн нислэгт үзүүлэх навигацийн үйлчилгээний явцад гуравдагч этгээдийн өмнө хүлээх хариуцлагын даатгалын гэрээг монгол хэлнээс англи хэл рүү орчууллаа.

3.4. Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, шаардлагатай судалгаа хийх, сургалт зохион байгуулах, сурталчлан таниулах зэрэг ажлыг зохион явуулах, төсөл, хөтөлбөрийн санхүүгийн тооцоолол хийх, батлуулах, зарцуулалтад хяналт тавьж ажиллах

Экспортыг дэмжих төслийн Экспортын шинэ санхүүгийн бүтээгдэхүүн хөгжүүлэх дэд бүрэлдэхүүн хэсэг 1.1-ийг хангах ажлын хүрээнд:

Экспортыг дэмжих төсөл Сангийн яамнаас ХХААХҮЯ руу шилжиж төслийн нэгдүгээр бүрэлдэхүүн хэсгийн санхүүжилтэд өөрчлөлт орсон. Уг өөрчлөлтөд тулгуурлан зах зээлийн судалгаа хийж Дэлхийн банкны төсөл хариуцсан мэргэжилтнүүдэд өглөө. Судалгаанд Монгол Улсын уул уурхайн бус экспортын өсөлт, бууралт, тээвэрлэлтийн өмнөх болон дараах бүтээгдэхүүн нэвтрүүлэх зах зээлийн багтаамж, түүнд тулгуурлан 3 жилийн борлуулалтын төлөвлөгөө зэргийг тусгасан. Мөн Сангийн яамнаас өгсөн чиглэл, Дэлхийн

банкнаас ирсэн саналын дагуу зах зээлийн төлөвлөгөөг дахин шинэчилж эцэслэн дуусгасан.

Нэмэлт санхүүжилтийг бүтээгдэхүүн хөгжүүлэлтээс гадна олон улсын давхар даатгалын хураамжийн зардал гэх мэт зарим үйл ажиллагааны зардалд зарцуулж болно. Нөөц сангаас бусад зориулалтаар ашиглах төслийн санхүүжилтийн хэмжээг тодорхойлох зорилгоор зах зээлийн судалгаанд үндэслэн дүн шинжилгээний тайланг боловсруулахыг Дэлхийн банк болон Сангийн яам, ХХААХҮЯ-аас даалгасан. Үүний дагуу үндэслэл, зах зээлийн тойм, хэрэгцээ шаардлага, зорилтот зах зээл ба зах зээлд нэвтрүүлэхээр сонгосон хоёр бүтээгдэхүүний үйл ажиллагааны 3 жилийн санхүүгийн төсөөлөлд үндэслэн төслөөс шаардагдах санхүүжилтийн хэмжээг тодорхойлсон дүн шинжилгээний тайланг боловсруулав. Уг тайланд зах зээлийн судалгаа боловсруулсан олон улсын зөвлөх профессор Андреас Класен болон мастер гэрээний цар хүрээг тодорхойлсон олон улсын зөвлөх Жеф Винсент нарт хүргүүлэн, цахим хурал хийж зөвлөхүүдийн саналыг тусгасан. Тайланг Дэлхийн банкны техникийн зөвлөх Арнауд Дорнелд илгээж, саналыг авахаар хүргүүлэв. Арнауд зөвлөхийн саналыг хүлээн авсны дараа Сангийн яам, Дэлхийн банканд танилцуулна.

Монголын экспортлогч нарт тулгарч буй саад бэрхшээлийг тодорхойлох зорилгоор судалгаа авах гэж байгаа бөгөөд уг судалгааны асуулгад оруулах экспортын даатгалтай холбоотой асуултуудыг боловсруулав. Уг асуултуудыг бүтээгдэхүүн хөгжүүлэлтэд ашиглана.

Экспортын зээлийн даатгалын ач холбогдлыг олон нийтэд таниулах, мэдээлэх зорилгоор олон улсын зөвлөх Андреас Класений европын орнуудын экспортлогчдоо дэмжиж буй бодлого, шийдэлд хийсэн дүн шинжилгээг эшлэн нийтлэл бичсэн. Уг бүтээгдэхүүнийг олон нийтэд танилцуулах, сурталчлах зорилготой “Худалдааны даатгалын ач холбогдол ба эдийн засагт үзүүлэх үр нөлөө” гэсэн сэдвээр нийтлэл бичиж сонин болон бусад олон нийтийн цахим хуудсанд нийтлүүлэв.

МҮХАҮТ болон Гадаад харилцааны яамны дэргэдэх ТРАМ /TRAM/ төсөл, Экспортыг дэмжих төсөл, Европ-Монголын хамтарсан худалдаа аж үйлдвэрийн танхим /EMXXAYT/ хамтран 7 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулсан Экспортын санхүүжилт сэдэвт уулзалтад давхар даатгалын ахлах менежер оролцлоо. Уг уулзалтаар одоо хэрэгжиж буй экспортын санхүүжилтийн бүтээгдэхүүний тухай болон цаашид ямар санхүүжилтийн бүтээгдэхүүн шаардлагатай байгаа талаар илтгэгчид танилцуулав. Уулзалтын хүрээнд Үндэсний давхар даатгал ХК-ийн боловсруулж буй экспортын даатгалын бүтээгдэхүүнийг нэвтрүүлэхэд хамтран ажиллах, туршлага солилцох талаар санал солилцов.

Экспортыг дэмжих төслийн зүгээс экспортлогч ААН-үүдийн захирлуудад экспортын санхүүжилтийн мэдлэг олгох 20 цагийн сургалт хийсэн ба үүнд 8 дугаар сарын 26-ны өдөр өдрийн ангид, 8 дугаар сарын 31-ний өдөр оройн ангид тус тус эргэлтийн хөрөнгийн даатгал, экспортын даатгал, тэдгээрийн олон улсын туршлагын талаар хичээл бэлтгэн орлоо. Сургалтанд нийт 30 гаруй хүн хамрагдсан болно.

Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилттэйгээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хэрэгжих Экспортыг дэмжих төслийн бүтцийн өөрчлөлтийг танилцуулах арга хэмжээ 2020 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулагдаж, бүртгэл зохион байгуулалтын чиглэлээр хамтран ажиллав. Уг арга хэмжээнд зориулж экспортын даатгалын бүтээгдэхүүний танилцуулга, стөндны загварын эхийг бэлтгэн төсөлд хүргүүлэв.

Дэлхийн банкны төслийн хэрэгжилтийг дэмжих хяналт, шалгалтын үйл ажиллагаанд цахимаар оролцов. Уг хяналт, шалгалтын хүрээнд 2020 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааг танилцуулсан.

Холбогдох төслүүдтэй хамтарч ажиллах, борлуулалтын сувгийг нэмэгдүүлэх чиглэлээр:

Сибелиус төслийн хүрээнд Сибелиус төслийн ахлах Ник Волкертой байнгын харилцаа холбоотой ажиллан Архангай аймагт явуулсан 278 малчны судалгааг нэгтгэн дүгнэж, үр дүн холбогдох мэдээллүүдийг хүргүүлэв.

2013 оноос хойш ашигт малтмалын үнэ буурч эхэлснээс хойш төрөөс хөдөө аж ахуйн салбарыг дэмжих бодлого баримталж, үүний дотор жижиг тариаланчдыг дэмжих нь орлогыг нэмэгдүүлэхээс гадна эрсдэлийг бууруулах ач холбогдолтой гэж үзсэн. Монгол Улсын хэмжээнд нийт 35000 ногоочин үйл ажиллагаа явуулж буй бөгөөд сүүлийн 5-6 жилд төмсний дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаж, бусад хүнсний ногооны 40-50 орчим хувийг хангаж байна. Хүнсний ногоочдыг байгаль цаг уурын өөрчлөлтөөс хамгаалах, ядуурлыг бууруулах, улмаар хүнсний аюулгүй байдлыг нэмэгдүүлэх, хүнсний ногоочид хэвийн үйл ажиллагаагаа явуулах нөхцөл бүрэлдүүлэх хамгаалалт бий болгох зорилгоор асуулга бэлтгэн ХХААХҮЯ болон бусад холбогдох байгууллагуудтай уулзан нийт 92 иргэн аж ахуйн нэгжээс судалгаа аваад байна. Судалгааны үр дүнд индексийн даатгалын бүтээгдэхүүнийг хэрэгжүүлж байгаа нэрлэсэн эрсдэлт улаан буудайн даатгалын бүтээгдэхүүнээс гадна бусад тариалангийн даатгалын бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх боломжийг судалсан.

Манай компани нь 2018 оноос Ард даатгал ХК, Бодь даатгал ХК, МИГ даатгал ХХК-уудтай нэрлэсэн эрсдэлт улаан буудайн даатгалын Хувь оролцооны давхар даатгалын гэрээ байгуулан ажиллаж байна. Нэрлэсэн эрсдэлт улаан буудайн даатгалыг уламжлалт хэлбэрээр хийдэг байсан бол Лейбник хөдөө аж ахуйн хөгжлийн институт /Leibniz Institute of Agricultural Development (IAMO)/-ын Хөдөө аж ахуйн зах зээл, маркетинг, дэлхийн хөдөө аж ахуйн худалдааны газартай хамтран индекс хэлбэрт шилжүүлэхээр тохиролцож, индекс бэлтгэх ажлыг эхлүүлээд байна. Түүнчлэн Герман-Монголын хамтын ажиллагааны “Тогтвортой хөдөө аж ахуй” төсөлтэй индексийн боловсруулалтад үндэслэн мэдээлэлд шинжилгээ хийх, индексийн тохиргоонд өөрчлөлт оруулахад хамтран ажиллахаар тохиролцов.

Тариалангийн даатгалын тухай хуулийн төслийн ажлын хэсэгтэй хамтарч ажиллах ажлын хүрээнд:

Тариалангийн даатгалын тухай хуулийн төсөлд компанийн зүгээс гаргасан саналыг нэгтгэж, ХХААХҮЯ-д хүргүүлэв. Гадаадын улс орнуудын /ОХУ, Узбекистан, Казахстан/ тариалангийн даатгалын тухай хуулийн матрицыг боловсруулж, ажлын гишүүдэд танилцуулав.

3.5. Олон улсын болон дотоодын төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудтай түншлэл хамтын ажиллагааг хөгжүүлэх

БНКаЗУ-ын Евроазия даатгалын компанитай хамтран ажиллах талаар санал солилцож, шаардлагатай мэдээ мэдээллүүдийг авч холбогдон ажиллав. Тус компаниас жил бүр зохион байгуулдаг “Эрсдэлийн менежментийн олон улсын бага хурал-2020” форумд манай компанийн төлөөллийг оролцох санал тавьсан. 2020 оны 4 дүгээр сард зохион байгуулагдах давхар даатгалын форумд оролцох төсөв, төлөвлөгөө гаргасан боловч цаг үеийн байдалтай холбогдуулан цуцлагдсан болно.

Францын олон улсын давхар даатгалын компани АХА-тай Хорт хавдар болон хүнд өвчний даатгалыг зах зээлд нэвтрүүлэхээр туршлага солилцон видео хурал, уулзалт хийн цахим шуудангаар харилцан ажилласан.

Хонгконгийн олон улсын давхар даатгалын ПИК РЕ /Peak Reinsurance Company” Limited буюу РЕАК РЕ/ компанитай холбогдож, ПИК РЕ-ээс тавьсан шинэ бүтээгдэхүүн, гэрээний санал болон үнийн санал дээр зөвшилцөж хамтран ажиллалаа. ПИК РЕ /Peak Re/ болон даатгалын компаниудын эмч, актуарчдыг оролцуулсан видео хурал, уулзалтуудыг зохион байгуулав. Хурлаар хүнд өвчний даатгалын гэрээний хамгаалалтад орж байгаа болон орохгүй байгаа өвчин өвчний нэр томъёо болон актуар тооцооллын асуудал дээр даатгалын компаниуд тодруулга авсан.

2020 онд зохион байгуулагдах Олон Улсын давхар даатгагчдын форум, хурал, хэлэлцүүлгийн жагсаалтыг гаргав. Цаг үеийн байдлаас хамаарч, форум, уулзалтууд цуцлагдсан болно.

Компанийн гадаад харилцааг хөгжүүлэх зорилгоор Бахрейн Улсын Протекшин Ре брокер компани, Малайзын холбооны улсын Ай Жи Ай Лабуан /IGI Labuan/ даатгалын компани, БНЭУ-ын Бхарат Ре брокер компаниудтай Сингапурын давхар даатгагчдын холбооноос /SIRC/ зохион байгуулсан онлайн хурлын үеэр холбогдон компанийн ерөнхий мэдээлэл солилцон ажиллалаа.

Сингапурын давхар даатгагчдын холбооноос /SIRC/ зохион байгуулсан онлайн хуралд 11 дүгээр сарын 4-ний өдөр оролцлоо. Тус хурлын АМ Бест олон улсын зэрэглэл тогтоогч байгууллагаас зохион байгуулсан салбар хуралдаанд оролцож олон улсын давхар даатгагчдыг хэрхэн үнэлж, зэрэглэл тогтоодог тухай мэдээлэлтэй болсон. Тус вэбинар /цахим хурал/-т оролцож авсан мэдээллийг “Үндэсний давхар даатгал ХК зэрэглэл тогтоолгох тухай товч судалгаа”-нд дэлгэрэнгүй оруулсан болно.

Агилэ Риск Партнерс /Agile Risk Partners/ олон улсын давхар даатгалын брокерын компанитай цахимаар харилцаж, хамтран ажиллах санал тавьсныг судалж байна.

3.6. Компанийн сургалт сурталчилгаа, гадаад харилцаа болон хамтын ажиллагааг бэхжүүлэх

МИД-ын борлуулалтыг идэвхжүүлэх зорилгоор шторк хийлгэхээр телевизүүдийн цацалтын үнийн санал болон хийлгэх студийн үнийн саналын судалгаа хийсэн. Шторкийг 5 дугаар сарын 01-ний өдөр Гацууртын аманд байрлах малчин айлынд очиж “Атаархуу Аглуу” сэдэвт тааруулан зураг авалт хийн бэлдлээ. Тус 4 минутын шторкийг Малчин телевизээр борлуулалтын хугацаа дуустал өдөрт 5 удаа цацалт хийлгэв.

МИД-ын шинэ нэвтрүүлэг бэлтгэх, малчдад нөхөн төлбөр олгох хүрээнд Архангай, Хөвсгөл, Булган аймгуудад томилолтоор ажиллав.

МИД-ын борлуулалтыг эрчимжүүлэх, малчдад таниулах үүднээс олон нийтийн цахим сүлжээ болох компанийн фейсбүүк /нүүр номын/ хуудсаар дамжуулан төлбөрт сурталчилгаа цацах төсвийн төслийг бэлдсэн. Уг төлбөрт сурталчилгааг газар нутгийн хувьд Улаанбаатар хотоос бусад орон нутгийн төвүүдийг сонгож цацсан бөгөөд зорилтот зах зээл болох малчдад түлхүү хүрсэн. Нийт 6 удаагийн төлбөрт сурталчилгаа цацсан ба давхардсан тоогоор 1.5 сая хүнд хүрсэн байна. Мөн фейсбүүк цахим хуудсанд МИД, улаан буудайн индексжүүлсэн даатгал болон бусад бүтээгдэхүүний талаар мэдээлэл өгөх автомат хариулагч /чатбот/ хийж малчид, иргэдэд цахим хуудсаар харилцаж, мэдээлэл хүргэлээ.

МИД-ын төлөөлөгчдийн борлуулалт нэмэгдүүлэх бизнес төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэгт давхар даатгалын ахлах менежер, маркетингийн менежер нар орон ажиллаж

байна. Ажлын хэсэг зарим аймгийн даатгалын салбаруудтай холбогдож даатгалын төлөөлөгчид борлуулалт хийхэд ямар асуудал тулгарч байгаа, түүнийг багасгахад ямар арга хэмжээ авч болох талаар судалгаа авлаа. Тулгамдаж буй хүндрэлүүдийг оролцогч даатгалын компани, зуучлагч банк, мөн Үндэсний давхар даатгал ХК-ийн хүрээнд хэрхэн багасгаж болох талаар төлөвлөгөө гарган ажиллаж байна. МИД-ын төлөөлөгчдийн борлуулалтыг эрчимжүүлэх маркетингийн ажлын төлөвлөгөө болон төслийг боловсруулсан ба ОБЕГ-аас зудын эрсдэлийн үнэлгээгээр 2021 оны өвөлжилт хүндрэх аймгуудад олон жил дараалан даатгуулсан ч нөхөн төлбөр аваагүй малчдад олгох нэг удаагийн тусламжийн төсвийг гаргалаа.

Монголиан экономи /Mongolian Economy/ сэтгүүлд Гүйцэтгэх захирлын болон компанийн үйл ажиллагааны талаар нийтлэл гаргав. Мөн ил уул уурхайн иж бүрэн давхар даатгалын үйлчилгээ үзүүлж буй тухай 1 нүүр зурагт хуудас /постер/ бэлдэж, сурталчлав.

Компанийн цахим хуудсанд мэдээллийг цаг тухайд нь нийтлэх чиглэлээр:

Компанийн веб сайт, олон нийтийн сүлжээний хуудаснууд болох фейсбүүк, твиттерт нийтлэх мэдээ, мэдээллийг бэлтгэх ажлыг удирдан зохион байгуулж, төлөвлөгөө боловсруулан газрын дарга нарт танилцуулан батлуулав. Бизнес хөгжил, төслийн газар, Андеррайтингийн газар, Компаенс, нөхөн төлбөрийн газар, Эрсдэлийн менежмент, хөрөнгийн удирдлагын газрын нийт 14 ажилтан орсон бөгөөд ажилтан тус бүр сард 1 удаа даатгал, санхүүгийн чиглэлээр мэдээг бэлтгэн ажиллаж байна. Ажилтнуудын бэлтгэсэн мэдээнээс даатгалын болон санхүүгийн салбарын танин мэдэхүйн мэдээг түүвэрлэн авч, засварлан веб сайт болон олон нийтийн сүлжээний хуудаснуудад оруулж байна. Мөн компанийн болон даатгалын тухай сонирхсон хүмүүст мэдээлэл өгч ажиллалаа.

Компанийн веб хуудсыг олон улсын нэр хүндтэй давхар даатгалын компаниудын жишгийн дагуу өөрчлөн, веб сайтын шинэ загварыг худалдан авч хөгжүүлэн, давхар даатгалын үйлчилгээ үзүүлж буй бүтээгдэхүүний мэдээллийг шинэчлэн ажиллаж байна.

Тайлант жилийн хугацаанд Эрсдэлийн хороо 10 удаа хуралдаж, компанийн эрсдэлийн шинжилгээг хянан дүгнэх, нөхөн төлбөрийн шийдвэр гаргах асуудлуудыг хэлэлцсэн.

Сургалт семинар, олон нийтийн үйл ажиллагаа зохион байгуулах ажлын хүрээнд:

Компанийн “Дотоод сургалтын төлөвлөгөө 2020”-д даатгалын мэргэжлийн институт болон банкнуудын холбооноос зохион байгуулах сургалтуудаас зайлшгүй шаардлагатай сургалтуудыг тусгаж орууллаа. Сургалтын төлөвлөгөөнд газрын ажилтнуудын ажлын чиг үүрэг, хийж гүйцэтгэх ажлын даалгавар зэргийг харгалзан сургалтад хамруулах ажилтнуудын хуваарийг гаргаж гүйцэтгэх удирдлагаар батлуулсан.

Компанийн ажилтнуудад 01 дүгээр сарын 22-ны өдөр Санхүүгийн зохицуулах хорооноос мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн талаар сургалт хийсэн ба уг сургалтад хамрагдаж компани тус хуулийн хэрэгжилтийг хангахад ямар журам боловсруулах талаар мэдээлэл авлаа.

Компанийн нийгмийн хариуцлага болон олон нийтийн үйл ажиллагааны хүрээнд “Мод тарих аян” энэ оны 10 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулж, Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд агч мод тарьж, ажилтнуудыг идэвхтэй хамрууллаа.

3.7. Компанийн бизнесийн стратеги төлөвлөгөө боловсруулах, биелэлтийг хангах, тайлагнах

Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал болох болсонтой холбогдуулан компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг багтаасан танилцуулга бэлтгэлээ.

Компанийн 2019 оны үйл ажиллагааны хэрэгжилтийн тайланг монгол хэлээр, компанийн товч танилцуулгыг англи хэлээр бэлдэж хэвлүүлсэн. Монгол хэл дээрх тайлан 300 хувь, англи хэл дээрх танилцуулга 300 хувь хэвлүүлэн харилцагчдад тараалаа.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулах компанийн 2020 оны үйл ажиллагааны болон төсвийн гүйцэтгэл, 2021 оны давхар даатгалын, шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх болон төсвийн төсөл болон холбогдох материалуудыг бэлтгэв.

Компанийн дунд хугацааны зорилтод чиглэсэн “Үндэсний давхар даатгал ХК зэрэглэл тогтоолгох тухай товч судалгаа”-г боловсрууллаа. Тус судалгаанд зэрэглэл тогтоогч байгууллагууд, зэрэглэл тогтоохдоо ямар аргачлал ашигладаг, шаардагдах барим бичгүүд болон компанийн одоогийн нөхцөл байдалд юуг сайжруулах шаардлагатай байгаа талаар тусгасан.

ДӨРӨВ. ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТ, ХӨРӨНГИЙН УДИРДЛАГЫН ТАЛААР ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД:

4.1. Компанийн сангийн хөрөнгө удирдах, зохицуулах, орлогын бүрдүүлэх

Нөөц сангийн мөнгөн хөрөнгийг холбогдох журмын дагуу байршуулах, удирдах:

Компанийн Дүрмийн сангийн хөрөнгийг 24.5 тэрбум төгрөг, Алдагдлаас хамгаалах сангийн хөрөнгийг 19.0 тэрбум төгрөг, Нөхөн төлбөрийн нөөц сангийн хөрөнгийг 4.38 тэрбум төгрөг болгон өсгөлөө.

2020 оны байдлаар гэрээний хугацаа дуусаж буй мөнгөн хадгаламжийг хөрөнгө зохицуулах журмын дагуу байршуулах ажлыг зохион байгуулан Гүйцэтгэх захирлын 2019 оны А/11 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг Гүйцэтгэх захирал болон Сангийн сайдын 95 дугаар тушаалын дагуу Сангийн яаманд танилцуулан хүлээн авсан чиглэл, шийдвэрийн дагуу дараах банкуудтай мөнгөн хадгаламжийн гэрээ байгуулан ажиллалаа.

Хадгаламжийн гэрээний хэрэгжилтийг хангаж, хүүгийн тооцоололд хяналт тавих, төвлөрүүлэх:

Сар бүр орж ирж буй хүүгийн орлогын тооцооллыг тулган баталгаажуулж, банкуудын Монголбанкнаас хянаж тооцсон болон өөрсдийн тооцсон “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцох, хяналт тавих журам”-ын дагуу тайлангийн хуулбар, сар бүрийн санхүүгийн тайланг авч, банкны холбогдох ажилтнуудтай хамтран ажиллалаа.

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахал гарсантай холбоотойгоор УИХ 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр “Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль”-ийг баталсан. Тус хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх заалтад “Цар тахлын үед банкны харилцах дансанд хүү тооцохгүй, гадаад валютын хадгаламжийг албан журмын даатгалд хамруулахгүй бөгөөд иргэн, хуулийн этгээд хоорондын гүйлгээг үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэнэ.” гэсэн заалтыг үндэслэн хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд харилцагч банкууд харилцах дансны хүүг тэглэх болсныг мэдэгдсэн.

Мөн Монголбанкнаас мөнгөний бодлогын хүүг 2020 оны 4, 9, 11 дүгээр саруудад тус тус буулгаж 6 хувь болгосонтой холбоотойгоор банкуудын хадгаламжийн хүү 1 орчим хувиар буурч байна. Цаашид Ковид-19 цар тахалтай холбоотойгоор УИХ, Засгийн газар болон бусад газруудаас авсан арга хэмжээнүүдээс шалтгаалж 2021 онд хүүгийн орлого буурах хандлагатай байна.

Нөөц сангуудын хөрөнгө оруулалтын хүүгийн орлого, зарлага зарцуулалтын мэдээг

2019 оны 4 дүгээр улирал болон 2020 оны 1, 2, 3 дугаар улирлын байдлаар гарган танилцууллаа.

Алдагдлаас хамгаалах сан болон Дүрмийн сангийн хөрөнгийн байршил хуваарилалтын хэрэгжилтийг хангах:

“Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн санхүүгийн нэмэлт тайлангийн агуулга, маягыг тогтоох журам”-ын 5 дугаар хавсралтын дагуу “Давхар даатгалын компанийн дүрмийн сангийн хөрөнгийн байршил” болон Давхар даатгагчийн алдагдлаас хамгаалах санг бүрдүүлэх, хуваарилах хэсгийн 5 дугаар хавсралтын дагуу “Алдагдлаас хамгаалах сангийн хөрөнгийн байршлын тайлан”-г 2020 оны 1, 2, 3, 4 дүгээр улирлын байдлаар гарган Санхүүгийн зохицуулах хороонд цаг хугацаанд нь хүргүүлэв.

4.2. Үндсэн тоо баримт, статистик дээр тулгуурлан зах зээлийн чиг хандлагыг урьдчилан таамаглаж, эдийн засгийн шинжилгээ, загварчлалыг мэргэжлийн түвшинд гаргаж, дүгнэх

Компанийн эрсдэлийг илрүүлэх, шинжилгээ хийх, хянах:

Үндэсний давхар даатгал ХК-ийн нийт эрсдэлийг илрүүлж, үнэлэх зорилгоор “Үндэсний давхар даатгал ХК-ийн дотоод болон гадаад эрсдэлүүд” судалгааг хийж гүйцэтгэсэн. Энэхүү судалгаагаар манай компанид нөлөөлөх томоохон эрсдэл нь нийгмийн эрсдэл, байгалийн эрсдэл болон хөрөнгө оруулалтын эрсдэл байхаар байна. Учир нь манай компанийн голлох даатгалын бүтээгдэхүүнүүд болох МИД, газар тариалангийн даатгал нь шууд байгалийн эрсдэлээс хамааралтай байдаг.

Ковид-19 цар тахлын вирусийн тархалттай холбоотой тодорхой бус байдал нэмэгдэж байгаагаас гадаад эрэлт, түүхий эдийн үнэ буурч, гадаад болон дотоод эдийн засгийн идэвхжил сулран, эдийн засгийн өсөлт үргэлжлэн саарах эрсдэлийг бий болгож байна. Цаашид эдийн засагт үзүүлэх нөлөө нь Ковид-19 вирусийн тархах цар хүрээ болон үргэлжлэх хугацаа, вирусийн эсрэг авч хэрэгжүүлэх арга хэмжээнээс ихээхэн хамаарахаар байна.

Энэхүү цар тахлаас үүдэн Монголбанк 2020 мөнгөний бодлогын хүүгээ 4 удаа өөрчилсөн. 2020 оны 3 дугаар сарын 12-нд 1 бүхэл нэгж хувиар бууруулж 10 хувь, 4 дүгээр сарын 12-нд 1 бүхэл нэгж хувиар бууруулан 9 хувьд мөн 9 дүгээр сарын 15-ны өдөр 1 нэгж хувь, 11 дүгээр сарын 23-ны өдөр дахин 2 нэгж хувиар бууруулан 6 хувьд хүргэсэн байна. Энэ нь банкуудын хадгаламжийн хүү дунджаар 1 хувь буурахад хүргээд байна.

Мөн Ковид-19 цар тахалтай холбоотойгоор “Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл, Хүнд нөхцөл байдал” судалгааг хийж гүйцэтгэсэн.

Хүнд нөхцөл байдал ба форс мажор нь хоорондоо төсөөтэй ч үүсэн бий болох нөхцөл, үр дагавар зэргээрээ ялгаатай. Хүнд нөхцөл байдал учирснаас аль нэг тал үүргээ бүрэн биелүүлэхэд хүндрэл бэрхшээлтэй байх буюу ийнхүү биелүүлээд ч ямар ч ашиггүй байх зэрэг үр дагавар гардаг бол форс мажор тохиолдоход гэрээ биелэгдэх боломжгүй болно. Хүнд нөхцөл байдал тохиолдоход талуудын гэрээ биелүүлэх төлөвлөгөө өөрчлөгдөх болдог бол форс мажорын нөхцөлд гэрээг цуцлах эсвэл хүчингүй болгоно. Товчоор хэлбэл форс мажор нь илүү бодит үзэгдлээр буюу байгалийн гамшиг, дайн зэргээр илэрдэг бол Хүнд нөхцөл байдал нь эдийн засгийн хямрал, улс төрийн нөхцөл байдлын өөрчлөлт зэрэг нийгмийн хүчин зүйлээс үүсдэг.

Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох журмын дагуу санхүүгийн үнэлгээ хийх:

Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны даргын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдөр баталсан “Даатгалын үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх журам”-ын дагуу Үндэсний давхар даатгалын ХК-ийн санхүү, эрсдэлийн шинжилгээг хийсэн.

2020 оны 3 дугаар улиралд борлуулалтын орлого өмнөх үетэй харьцуулахад 77 хувиар нэмэгдсэн. Бусад харьцаануудын хувьд боломжит түвшнийг ханган ажиллаж байна.

4.3. Компанийн даатгалын үйл ажиллагаанд шаардагдах актуар тооцоолол хийх
Шинэ болон хэрэгжүүлж буй даатгалын бүтээгдэхүүний хувьд зах зээл дээрх боломжит тоон мэдээллийг цуглуулах, боловсруулах, дүн шинжилгээ хийх:

ХХААХҮЯ-ны харьяа Хөдөө аж ахуйг дэмжих сан /Сан/-ийн хүсэлтийн дагуу Улаан буудайн индексжүүлсэн даатгал боловсруулах ажлын хүрээнд Герман-Монголын хамтын ажиллагааны “Тогтвортой хөдөө аж ахуй төсөл”-ийн хамтран ажиллагч зөвлөх байгууллага “Лейбницийн шилжилтийн эдийн засаг дахь хөдөө аж ахуйн хөгжлийн хүрээлэн”-ээс /IAМО/ 185 багийн 2000 оноос 2020 оны индексийн мэдээг авч, 1400 гаруй аж ахуйн нэгжийн баг тус бүрээр мэдээллийг эмхэтгэв.

2019 оны улаан буудай тариалсан 13 аймгийн 72 сумын нийт 2000 гаруй аж ахуйн нэгжийн тариалсан талбайн хэмжээ, хураан авсан ургацын дүн мэдээг авч эмхэтгэв.

Уурхайн хүнд машин механизмын трити давхар даатгалын бүтээгдэхүүн боловсруулах ажлын хүрээнд Монгол даатгал ХК, Амар даатгал ХХК, Бодь даатгал ХК, Номин даатгал ХХК, Практикал даатгал ХХК, Хаан даатгал ХХК-ийн уул уурхайн хүнд машин механизмын даатгалын гэрээнээс учирсан түүхэн хохирлын мэдээллийг авч, эмхэтгэлээ.

Хэрэгжүүлж буй бүтээгдэхүүний хохирол үнэлгээний актуар тооцооллыг хийх, учирч болзошгүй эрсдэлийг үнэлэх:

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 3 дугаар сарын 06-ны өдрийн 9/764 тоот албан бичгээр ирсэн Үндэсний давхар даатгал ХК-ийн 2019 оны 4 дүгээр улирлын тайлангийн хариунд “давхар даатгалын факультатив, гэрээт /proportional, non-proportional, quota share, surplus share, Stop loss, Excess of loss/-нээс хамааруулан даатгалын нөөц санг тооцоолж байгуулах нь зүйтэй юм.” гэж заасны дагуу хувь оролцооны болон хохирол хэтрэлтийн давхар даатгалын гэрээний хариуцлагад хамааруулан нөөц санг үнэлж байна.

Санхүүгийн зохицуулах хорооны ажлын албаны даргын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 290 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Эрсдэлд суурилсан хөрөнгө тооцох аргачлал”-ын дагуу хийгдсэн давхар даатгалын гэрээний хураамжийн эрсдэл, нөөц сангийн эрсдэлийг тооцоолж, танилцууллаа. Эрсдэлд суурилсан хөрөнгийн RBC харьцаа нь 2019 оны 4 дүгээр улирлын байдлаар 255 хувь 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар 248 хувь, 2 дугаар улирлын байдлаар 204 хувь, 3 дугаар улирлын байдлаар 197 хувь байгаа буюу даатгагчийн өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд зөвшөөрөгдөх хөрөнгө нь хүрэлцэхүйц хэмжээнд байна.

Компанийн актуар тайланг цаг хугацаанд нь гаргаж Санхүүгийн зохицуулах хороонд хүргэх:

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 02 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгалын багц дүрэм”-ийн гуравдугаар хавсралт болох “Даатгалын нөөц сан, албан журмын даатгалын сан болон бусад санг бүрдүүлэх, хуваарилах, түүнд хяналт тавих журам”, наймдугаар хавсралт болох “Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох, актуарын стандарт, үнэлгээ болон актуарчийн хяналт шалгалт

хийх, тайлан гаргах журам”-ын дагуу 2019 оны 4 болон 2020 оны 1, 2, 3 дугаар улирлын байдлаар нөөц сангийн тооцоолол болон үр дүнг танилцуулсан актуарын тайланг бэлтгэж Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлсэн.

“Даатгалын багц дүрэм”-ийн хоёрдугаар хавсралт болох “Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ын дагуу төлбөрийн чадварын харьцаа 2019 оны 4 дүгээр улирал болон 2020 оны 1, 2, 3 дугаар улирлын байдлаар төлбөрийн чадварын зохистой харьцаа нь тус тус 127.04, 129.08, 129.26, 131.03 хувьтай байгаа нь дээрх журмын 2.18-т “Даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцаа нь 110 хувь буюу түүнээс илүү байвал зохино” гэж заасан шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллаж байна.

Мөн “Даатгалын багц дүрэм”-ийн наймдугаар хавсралт болох “Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох, актуарын стандарт, үнэлгээ болон актуарчийн хяналт шалгалт хийх, тайлан гаргах журам”-ын дагуу 4.1, 4.3-т заасны дагуу Үндэсний давхар даатгал ХК-ийн 2019 оны олон улсын аудитын хийсэн актуарын хяналт шалгалтын тайлан, тайланг гаргасан актуарчийн олон улсын актуарчдын холбооны сертификатын хамт Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлсэн.

4.4. Байгууллагад учирч болзошгүй даатгалын болон даатгалын бус эрсдэлүүдийг тодорхойлж, эрсдэлийн удирдлагын зохистой арга аргачлалуудыг ашиглан тухайн эрсдэлүүдийг үнэлэх

Зах зээлийн бүтээгдэхүүний талаарх судалгаа хийх:

Компанийн учирч болзошгүй эрсдэлийг илрүүлэх, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг үнэлж, бууруулах арга замыг тодорхойлох, эрсдэлийг удирдахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 08 дугаар тогтоолоор батлагдсан “Үндэсний давхар даатгал хувьцаат компанийн эрсдэл болон төлбөрийн чадварыг үнэлэх аргачлал” болон бусад арга аргачлалыг мөрдлөг болгож “Эрсдэлийн удирдлагын журам”-ын төслийг бэлтгэн, хянуулж, Гүйцэтгэх захирлын 2020 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн А/32 дугаар тушаалаар батлагдсан.

Тус журмын хүрээнд компанийн эрсдэлийн судалгаа хийж холбогдох газруудаас мэдээ мэдээллийг авч, судалгааны ажлыг хийлээ. “Эрсдэлийн судалгаа”-нд компанийн бүх газар нэгж, ажилтнууд оролцон санал, дүгнэлтүүдийг нэгтгэхэд судалгаагаар зайлшгүй бууруулах 3 эрсдэл, хүлцэж болох 14 эрсдэл, бага эрсдэлтэй 3 эрсдэлүүдийг тус тус илрүүлэв.

Даатгалын хураамжийн урамшуулал, хөнгөлөлтийн тухай судалгааг хийж байна. Энэхүү судалгааг хийснээр МИД-д олон жил тасралтгүй даатгуулсан боловч нөхөн төлбөр авч байгаагүй даатгуулагчдад хураамжийн урамшуулал, хөнгөлөлт олгох боломж болон газар тариалангийн даатгал хийгдэхэд даатгуулагч нь хүний нөөц, усжилт, газар зүйн байршил зэргээс шалтгаалан хураамжид өөрчлөлт орох боломжтой.

Хөрөнгө оруулалтад учирч болох эрсдэлийн судалгаа хийх:

2020 онд Ковид-19 цар тахал гарсантай холбоотойгоор Монгол Улсын эдийн засагт их хэмжээний нөлөө үзүүлж байна. Энэхүү нөлөөллийн улмаас Төв банк шатлалтайгаар мөнгөний бодлогын хүүг 6 хүртэл хувь болгон бууруулсан. Манай байгууллагын хувьд нөөц сангийн мөнгөн хөрөнгийг арилжааны банкуудад зохих журмын дагуу хугацаатай хадгаламж хэлбэрээр байршуулдаг нь мөнгөний бодлогын хүү буурснаар арилжааны банкуудын хадгаламжийн хүү буурч, мөн банкууд өөрийн хөрөнгөө эрсдэл даах хэмжээнд хүргэн ажиллаж байгаа ч зарим банкууд бүрэн хангаж ажиллаж чадахгүй асуудал гарч байгаатай холбогдуулан цаашид нөөц сангийн мөнгөн хөрөнгийг хэрхэн зөв оновчтойгоор байршуулах асуудал гарч ирж байна. Иймд Хөрөнгө оруулалтын оновчтой хэлбэрийг сонгосноор эдийн

засгийн өсөлт саарсан үед байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах болон хөрөнгө оруулалтад нөлөөлөх эрсдэлээ зөв тооцон хуваарилж эрсдэлээ бууруулахад эерэг нөлөө үзүүлнэ.

ТАВ. КОМПЛАЕНС, НӨХӨН ТӨЛБӨРИЙН АЖЛЫН ХҮРЭЭНД:

5.1. Нөхөн төлбөрийн хэмжээг тооцоолох, олгох

Үндэсний статистикийн хорооны 2020 оны хагас жилийн мал тооллогын дүнд үндэслэн МИД-ын 2019 оны борлуулалтын жилд даатгалд хамрагдсан 32,337 малчин өрхийн 12.5 хувь буюу 10 аймгийн 52 сумын 4036 малчин өрхөд 600,924,229.79 /зургаан зуун сая есөн зуун хорин дөрвөн мянга хоёр зуун хорин есөн төгрөг далан есөн мөнгө/ төгрөгийн нөхөн төлбөр олгогдохоор тооцоолол хийгдсэн бөгөөд хамгийн өндөр нөхөн төлбөрийг Хөвсгөл болон Архангай аймгийн малчин өрхүүд авахаар болсон байна. Архангай аймгийн Хайрхан сумын харьяат Отгон овогтой Дорж нь 2019 онд малаа даатгуулахдаа нийт 3,050,000 /гурван сая тавин мянга/ төгрөгийн хураамж төлсөн бөгөөд 2020 оны нөхөн төлбөрт нийт 7,428,360 /долоон сая дөрвөн зуун хорин найман мянга гурван зуун жаран/ төгрөгийг авахаар тооцоологдсон. Нөхөн төлбөр авахаар тооцоологдсон 4036 малчин өрхийн 38.2 хувь буюу 1542 малчин өрх 2019 онд төлсөн хураамжаасаа өндөр нөхөн төлбөр авахаар тооцоологдсон бол 61.8 хувь буюу 2494 малчин өрх 2019 онд төлсөн хураамжаасаа бага нөхөн төлбөр авахаар тооцоологдсон.

Улаан буудайн индексжүүлсэн даатгалын хүрээнд 387 аж ахуйн нэгж 6, 7 дугаар саруудад учрах ган, мөндөр, гал түймрийн эрсдэлийн даатгалд даатгуулсан ба үүнээс 42 аж ахуй нэгж нэмэлт эрсдэл буюу 8, 9 дүгээр саруудад учрах хяруу, хүйтрэлт, цасны эрсдэлийн даатгалд хамрагдсан. Хүрээлэн /IAMO/-ээс сансрын хиймэл дагуулын цуглуулсан ургамлын ногоорлын тоон мэдээлэл дээр үндэслэн тооцоолол хийхэд даатгалд хамрагдсан 387 аж ахуйн нэгжээс нийт 32 аж ахуй нэгж 75,491,437.92 /далан таван сая дөрвөн зуун ерэн нэгэн мянга дөрвөн зуун гучин долоон төгрөг ерэн хоёр мөнгө/ төгрөгийн нөхөн төлбөр авах тооцоолол хийгдсэн. Нэмэлт эрсдэл буюу 8, 9 дүгээр саруудад учрах хяруу, хүйтрэлт, цасны эрсдэлийн даатгалд хамрагдсан 42 аж ахуй нэгжээс эрсдэлийн дуудлага өгсөн аж ахуй нэгжүүдэд урьдчилсан болон бодит ургац тогтоолт хийн тооцоолол хийхэд нийт 12 аж ахуйн нэгж 241,304,400 /хоёр зуун дөчин нэгэн сая гурван зуун дөрвөн мянга дөрвөн зуун/ төгрөгийн нөхөн төлбөр авахаар тооцоологдсон байна. 2020 онд улаан буудайн индексжүүлсэн даатгалд нийт 316,795,838.90 /гурван зуун арван зургаан сая долоон зуун ерэн таван мянга найман зуун гучин найман төгрөг ерэн мөнгө/ төгрөгийн нөхөн төлбөр олгохоор тооцоологдсон.

5.2. Компанийн бизнес төлөвлөгөөнд тусгагдсан Компаенс, нөхөн төлбөрийн газрын чиг үүргийг гүйцэтгэх

Санхүүгийн зохицуулах хороо, Санхүүгийн мэдээллийн албанаас зөвлөгөө, мэдээлэл авч, компанийн “Дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр”-ийг холбогдох хууль, журамтай нийцүүлэн боловсруулсан. Мөн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны талаар дотоодын харилцагч хувь хүн болон байгууллагаас авах харилцагчийг таньж мэдэх асуулгын загварыг шинээр боловсруулсан.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны талаар дотоодын харилцагч хувь хүн, байгууллага болон гадаад улсын харилцагч байгууллагаас авах харилцагчийг таньж мэдэх асуулгын загвар боловсрууллаа.

Санхүүгийн зохицуулах хороонд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны тоон болон чанар /компаенс/-ын тайланг гаргаж хүргүүллээ.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 02/06 тоот тогтоолоор батлагдсан Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК-ийн “Хөрөнгө зохицуулах журам”-ыг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан шийдвэртэй нийцүүлэн шинэчлэн боловсруулж, удирдлагуудад танилцуулж саналыг нь авч дуусгасан. Мөн Гүйцэтгэх захирлын тушаалаар батлуулах “Нөхөн төлбөрийн журам”, Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор батлуулах “Дотоод аудитын журам”-ын төслийг тус тус шинээр боловсруулаад байна.

5.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын үйл ажиллагааг зохион байгуулах, шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллах

Ковид-19 цар тахалтай холбогдуулан Үндэсний давхар даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны анхдугаар хуралдааныг 2020 оны 3 дугаар сарын 25-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулсан. Уг хурлаар компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланг хэлэлцэж, хангалттай сайн гэж дүгнэн Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахаар шийдвэрлэсэн.

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга болон Ерөнхий хуульч нь Төлөөлөн удирдах зөвлөл, Хувьцаа эзэмшигчдийн хурлын материал, гарах шийдвэрийн төслийг бэлтгэн тухай бүр Сангийн яаманд хүргүүлж ажилласан.

ЗУРГАА. ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА

6.1. Компанийн хүний нөөц, хөдөлмөрийн харилцаа, нийгмийн асуудлыг шийдвэрлэх

Компанийн нэр өөрчлөгдсөнтэй холбоотойгоор нийт ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгуулсан. Мөн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн баталсан бөгөөд ажлын чиг үүрэг нь өөрчлөгдсөн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг тухай бүр шинэчилсэн.

Ажилтнуудын ажилласан жил, удаан жилийн нэмэгдэл олгох жил, ээлжийн амралт олгох жилийг нарийвчлан гаргаж ажилтан тус бүрд танилцуулж гарын үсэг зуруулан баталгаажуулсны үндсэн дээр нэмэгдэл цалин болон ээлжийн амралтыг олгож байна.

Ажилтнуудын нийгмийн хамгаалал, олон нийтийн арга хэмжээ:

Компанийн 2020 оны олон нийтийн арга хэмжээний төлөвлөгөөг ажилтнуудаас санал аван боловсруулж Гүйцэтгэх захирлын тушаалаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Ковид-19 цар тахлын улмаас эрх бүхий байгууллагаас гаргасан олон нийтийн арга хэмжээг зохион байгуулахыг хориглосон шийдвэрийн дагуу зарим арга хэмжээнүүд хойшлогдсон буюу цуцлагдсан.

Ажилтнуудыг мэргэжил арга зүйн чиглэлээр чадавхжуулах сургалт:

Компанийн 2020 оны Дотоод сургалтын төлөвлөгөөг газруудаас санал авч нэгтгэн Гүйцэтгэх захирлын тушаалаар батлуулсан. Ковид-19 цар тахлын улмаас зарим сургалтууд тодорхойгүй хугацаагаар хойшлогдсон.

6.2. Компанийн санхүүгийн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилтийг хангах

Улирал бүрийн санхүүгийн болон татварын тайлан, баланс, сар бүрийн төсвийн гүйцэтгэлийг гаргаж холбогдох газруудад мэдээлж ажиллалаа.

2020 оны хүлээгдэж буй төлөвлөгөөний гүйцэтгэл, 2021 оны санхүүгийн төсвийн төслийг бэлтгэж Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулан батлуулсан.

Компанийн бүртгэл болон санхүүгийн үйл ажиллагааг 2019 оны 5 дугаар сарын 10-ны өдөр батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийн дагуу үнэн зөв хэрэгжүүлэн ажиллаж байна.

Мөн шинээр нэвтрүүлсэн санхүү, даатгалын цогц программ хангамжийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс үйл ажиллагаанд ашиглан, гарсан алдааг тухай бүрд залруулан, санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээг бүртгэлд бүрэн тусган ажиллалаа.

Санхүүгийн 2020 оны тайлан, анхан шатны баримтуудыг нэгтгэн архивлаж Грант торнтон аудит ХХК-д хүлээлгэн өгч гэрээний дагуу аудитын үйлчилгээнд хамтран ажиллаж байна.

Цалингийн гэрээтэй банктай цахимаар цалин дамжуулах гэрээ хийсэн. Цахимаар цалин дамжуулах үйлчилгээ нь хэзээ ч, хаанаас ч банкны салбар орох шаардлагагүйгээр үргэлж нээлттэй 24/7 цагийн горимоор цалингийн гүйлгээг хурдан шуурхай дамжуулах боломжтой үйлчилгээ юм.

Манай компанийн хийж буй бүх давхар даатгалын гэрээний мэдээллийг нэг бүрчлэн шалгаж, орлогыг тухай бүрд даатгалын программд холбож байна. Энэхүү холбох үйл явцад гарч байсан алдаануудыг Финтек солюшнс ХХК-ийн ажилтантай холбогдож нэмэлт сайжруулалт хийснээр /зуучлалын хөлс, ханшны зөрүү гэх мэт/ алдааг бууруулсан.

Ковид-19 цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор манай улсын валютын урсгал багассан. Иймд 2020 оны гэрээт Олон улсын давхар даатгалын төлбөрийг төлөхийн тулд арилжааны даатгалын компаниудын хураамжийг хүлээлгүйгээр, компанийн дотоод нөөц бололцоогоороо гадаад валютын нөөцийг бүрдүүлж, ханшны алдагдлаас урьдчилан сэргийлсэн зохицуулалтыг хийсэн.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны асуулга мэдээ, тайлангуудыг сар бүр холбогдох байгууллагуудад илгээж байна.

Хувь хүний орлогын албан татварын 2020 оны хөнгөлөлтийг ажилтан тус бүрээр албан татвар ногдуулах жилийн орлогын хэмжээг бодон гаргаж албан татвар хөнгөлөлтийн хэмжээг тодорхойлсон.

6.3. Компанийн худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулж хэрэгжүүлэх чиглэлээр

Компанийн худалдан авалтын үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хүрээнд:

Худалдан авах ажиллагааны 2019, 2020 оны тайлангуудыг бэлтгэн Сангийн яаманд хүргүүлсэн.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу Тээвэр шатахуун худалдан авах ҮДДХК/202001005 дугаартай тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр зарлан, 22-ны өдөр тендерийг нээж, 23-ны өдөр дүгнэсэн. Тендерт Петростар ХХК шалгарсан.

Сурталчилгааны материал хэвлүүлэх ҮДДХК/202001003 тендерийг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр зарлаж, 02 дугаар сарын 20-ны өдөр нээн, 3 дугаар сарын 04-ний өдөр дүгнэсэн. Тендерт шалгарсан Координат эдвайс ХХК-тай гэрээ байгууллаа.

Компьютер худалдан авах ҮДДХК/202001004 дугаартай тендерийг харьцуулалтын аргаар 2020 оны 3 дугаар сарын 12-ны өдөр зарлаж, 19-ний өдөр нээж, тендер шалгаруулалтын дүнг 31-ний өдөр гаргасан. Шалгаруулалтын үр дүнд Мон тех дистрибьюшн ХХК шалгарав.

Төрийн худалдан авах ажиллагааны газарт 2020 оны 3 дугаар сарын 16-ны өдөр ерөнхий гэрээгээр худалдан авах боломжтой бараа бүтээгдэхүүний судалгааг гарган хүргүүлсэн.

Санхүүгийн 2020 оны тайланд аудит хийх, зөвлөх үйлчилгээний тендер 2020 оны 8 дугаар сарын 25-ны өдөр товлосон хугацаандаа “Өдрийн сонин” болон tender.gov.mn сайтуудаар зарлагдаж 2020 оны 9 дүгээр сарын 04-ний өдөр хураангуй жагсаалтад орсон 6 аудитын компанид тендерийн баримт бичгийг хүргүүлсэн. Тендерийг 2020 оны 10 дугаар сарын 05-ны өдөр нээж шалгаруулалтын үр дүнд Грант торнтон аудит ХХК хамгийн бага үнийн саналаар шалгарч 2020 оны 10 дугаар сарын 26-ны өдөр гэрээ байгуулан ажиллаж байна.

Ажлын байр, техник хэрэгсэл, эд зүйлийн хангамж, бүртгэл, хадгалалт, хамгаалалтыг сайжруулан зохион байгуулах чиглэлээр:

2019 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын дагуу ашиглах боломжгүй, актлах хөрөнгийн жагсаалтыг гарган Өмч хамгаалах байнгын зөвлөлд танилцуулсан.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний 2019 оны дүгнэлтийг бэлтгэн 2020 оны 7 дугаар сарын 28-нд www.pcsp.gov.mn хаягаар хүргүүллээ.

Гүйцэтгэх захирлын 2020 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн А/41 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг эд хөрөнгийн тооллогыг 2020 оны 5 дугаар сарын 27-ны өдрөөс 6 дугаар сарын 04-ний өдрийг хүртэлх хугацаанд хийж, зарим хөрөнгийг эзэмшиж байсан эзэмшигч өөрчлөгдсөн байсныг Санхүү даатгалын цогц программ хангамж болон Юникус програмуудад дотоод гүйлгээгээр шинэ эзэмшигчид шилжүүлэн бүртгэж, тооллогоор ашиглалтын хугацаа дууссан, ашиглах боломжгүй болсон нийт 42 нэр төрлийн эд хөрөнгийг актлах хүсэлтээ гаргаж Өмч хамгаалах байнгын зөвлөлд санал хүргүүлсэн.

Ажилтнуудад эзэмшүүлэхээр өгсөн эд хөрөнгө, компьютер, бусад техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг картаар хүлээлгэн өгч, кодолж бүртгэн, хөдлөлт өөрчлөлтийг тухай бүрд хөтлөн картаар баталгаажуулан хүлээлцэж байна.

Засгийн газрын тогтоолын дагуу гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд ажилтнуудынхаа хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг ханган нүүрний хаалт, амны хаалт, гар ариутгагч, ариутгалын бүтээгдэхүүнээр хангаж, ажлын байрны цэвэрлэгээ ариутгалыг тогтмол хийлгэж, халдвар хамгааллын дэглэмийг сахин ажилчдыг ээлжээр ажиллуулах, хурал, уулзалтыг онлайнаар зохион байгуулах зэргээр компанийн үйл ажиллагааг тасалдуулалгүй хэвийн явуулж байна.

6.4. Компанийн компьютер, техник хэрэгсэл, хэрэглээний программ хангамжийн бүрэн бүтэн байдлыг ханган ажиллах

Вирусийн эсрэг Kaspersky программыг байгууллагын нийт 30 компьютерт 1 дүгээр сард суулгасан бөгөөд ажилтнуудын компьютерүүд найдвартай ажиллаж байна. 10 ажилтны компьютерыг шинэчилсэн ба бүх шаардлагатай програмуудыг суулгасан. Ажилтнуудын компьютерүүд дээрх Microsoft Office болон Lan, Acrobat Reader зэрэг хэрэглээний програмуудын хэвийн ажиллагааг ханган ажиллаж, сервер компьютерын хуваалцах хуудас /шэйр/ дээр архивлан байрлуулсан.

Компанийн дотоод сүлжээний нууцлал болон хяналтын камеруудын нууцлалыг хангаж ажилласан. Компанийн цахим хуудсыг ажиллуулж домайн нэр хостын /файлын серверт эзлэх хэмжээ/ нууцлалыг ханган ажилладаг.

6.5. Компанийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах

Ажилтнуудын хувийн хэргийг шинэчлэн бүртгэж дутуу бичиг баримтуудыг авч хувийн хэргийг бүрдүүлсэн. Шинээр ажилд орсон 3 ажилтны хувийн хэргийг бүрдүүлж хөтөллөө.

Ажилтнуудын боловсрол, ажилласан жил, гэр бүлийн байдал, авсан гавьяа шагнал зэргийн судалгааг цаг тухай бүр хийдэг. Хүний нөөцийн программтай болсон бөгөөд ажилтнуудын мэдээллийг оруулж байна.

Тайлант хугацаанд нийт 260 албан бичиг, Гүйцэтгэх захирлын 120 тушаал /А;Б/-ыг холбогдох удирдлагуудаар хянуулж албан бичгийн стандартын дагуу хэвлэж гаргав. Мөн 160 албан бичиг хүлээн авч удирдлагаар цохолт хийлгэн шийдвэрлүүлж ажиллалаа. Компанийн ирсэн, явсан бичиг болон Захирлын тушаал, тушаалын биелэлт, Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол зэргийн цахим бүртгэлийг цаг тухай бүрд нь хөтөлдөг. 2014-2020 оныг хүртэлх цахим бүртгэлийн баазыг бий болгоод байна.

Тайлант хугацаанд Захирлын зөвлөлийн 23 удаагийн хуралдаан болсон бөгөөд Захирлын зөвлөлийн хурлаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг дотоод сүлжээнд байрлуулж байна.

Компанийн 2019 оны үйл ажиллагааны тайланг нэгтгэн боловсруулж удирдлагуудаар хянуулан дүгнүүлсэн. Компанийн 2020 оны хагас жилийн болон жилийн үйл ажиллагааны тайланг нэгтгэн удирдлагаар хянууллаа.

6.6. Компанийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийх ажлын хүрээнд

Компанийн 2020 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд дотоод аудит хийсэн. Шалгалтаар илэрсэн дутагдлыг тухай бүр хариуцсан ажилтанд мэдэгдэж дутагдлыг засаж залруулсан.

Компанийн шилэн дансны мэдээлэлд хяналт шалгалт хийж ажилласан.

Компанийн худалдан авалт Төрийн болон орон нутгийн өмчийн, хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу хийгдсэн эсэхэд шалгалт хийж ажилласан. Компанийн худалдан авалтууд нь Төрийн болон орон нутгийн өмчийн, хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд хийгдсэн байна.

Компанийн 2019 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн аудит хийсэн Грант торнтон аудит ХХК-ийн өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан зөвлөмжийн хэрэгжилт, төлөвлөгөөний биелэлтийг гаргаж Аудитын хорооны дарга, гишүүдэд тайлагнасан.

Компанийн дүрмийн сан болон бусад сангийн хөрөнгийг банкнуудад байршуулахдаа Монголбанкны тооцсон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж байгаа эсэхийг шалгаж байж хадгаламж байршуулсан эсэх, мөн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн хорооны даргад тухайн шийдвэрийг танилцуулсан эсэхийг хянаж ажилласан. Компанийн дүрмийн сан болон бусад сангийн хөрөнгийг холбогдох журмын дагуу байршуулсан байна.

ДҮГНЭЛТ

А. Тайлант онд өмнөө тавигдсан зорилго, зорилтоо биелүүлэн ажиллаж, дараах үр дүнд хүрсэн байна. Үүнд:

- МИД-ын борлуулалтаар 2020 онд 28.5 мянган малчин өрхийг даатгалд хамрагдаж, 99.8 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий 7.1 сая толгой малыг даатгалд хамруулан нийт 3.48 тэрбум төгрөгийн хураамжийн орлогыг төвлөрүүлсэн.
- МИД-ын эрсдэлийн дээд болон дунд түвшний давхар даатгалын гэрээг СКОР /тэргүүлэгч/ болон Свисс Рэ /дагалдагч/ олон улсын давхар даатгалын компаниудтай байгууллаа.
- Улаан буудайн индексжүүлсэн даатгалын борлуулалтаар 2020 онд 387 аж ахуйн нэгж даатгалд хамрагдаж, 15.1 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий 22.5 мянган га

талбайг даатгалд хамруулан 539.0 сая төгрөгийн хураамжийн орлогыг төвлөрүүлсэн. Энэхүү 15.1 тэрбум төгрөгийн хариуцлагын 80 хувь буюу 12.0 тэрбум төгрөгийн хариуцлагыг СКОР олон улсын давхар даатгалын компанид давхар даатгууллаа.

- Үндэсний давхар даатгал ХК-ийн давхар даатгалын үйл ажиллагаа явуулах, андеррайтинг хийх, давхар даатгалын гэрээ, баталгааны төсөл боловсруулах, хянах, гэрээ байгуулах, баталгаа гаргахтай холбогдсон харилцааг зохицуулсан “Андеррайтингийн журам”-ыг боловсруулж, батлуулсан.
- Дотоодын даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулдаг 12 даатгалын компани, Ай Ай Би давхар даатгалын брокер болон гаднын Жи Би Бода олон улсын брокер компаниудтай хамтарч ажиллалаа.
- Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Засгийн газрын бүрэлдэхүүн хэсэг болох Английн сансрын агентлагийн санхүүжилттэй “Сибэлиүс” төсөлтэй хамтран хиймэл дагуулын мэдээлэлд суурилсан даатгалын бүтээгдэхүүнийг боловсруулж, малчдыг санхүүгийн эрсдэлээс хамгаалан, малчдын амьжиргааг сайжруулах зорилгоор хамтран ажиллалаа.
- Компанийн бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэх, хамтын ажиллагааг хөгжүүлэх хүрээнд МҮХАҮТ-ийн Платинум гишүүнээр элссэн. Гишүүнээр элссэнээр танхимын мэдээллийн сувгуудаар компанийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн үйлчилгээгээ сурталчлан, шаардлагатай бизнес, эдийн засгийн судалгаануудыг цаг тухайд нь авч, цахим сургалтуудад хамрагдсан.
- Компанийн веб хуудсыг олон улсын нэр хүндтэй давхар даатгалын компаниудын жишгийн дагуу өөрчлөн, веб сайтын шинэ загварыг худалдан авч хөгжүүлэн, давхар даатгалын үйлчилгээ үзүүлж буй бүтээгдэхүүний мэдээллийг шинэчлэн ажиллаж байна.
- Тайлант онд Дүрмийн сан 24.5 тэрбум төгрөг, Алдагдлаас хамгаалах сан 19.0 тэрбум төгрөг, Нөхөн төлбөрийн нөөц сан 4.385 тэрбум төгрөг, Хөрөнгө оруулалтын хүүгийн орлого 2.189 тэрбум төгрөг нийт 50.07 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын багцыг бүрдүүлж ажиллалаа.
- Компанийн учирч болзошгүй эрсдэлийг илрүүлэх, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг үнэлж, бууруулах арга замыг тодорхойлох, эрсдэлийг удирдахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор “Үндэсний давхар даатгал хувьцаат компанийн эрсдэл болон төлбөрийн чадварыг үнэлэх аргачлал” болон бусад арга аргачлалыг мөрдлөг болгож “Эрсдэлийн удирдлагын журам”-ын төслийг боловсруулан батлуулсан.
- Давхар даатгалын гэрээгээр хүлээх хариуцлагатай уялдуулан, учирч болзошгүй хохирлын хэмжээг таамаглаж, тухайн хохирол гарсан тохиолдолд гэрээний хариуцлагыг хүлээх зорилгоор найдвартай болоод хүрэлцээтэй нөхцөлд нөөц санг байгуулж, нэмэгдүүлэн ажилласан. Нөөц санг байгуулахдаа Санхүүгийн зохицуулах хорооны журмыг баримталсан бөгөөд тайлант онд нийт нөөц сангийн хэмжээ 553.5 сая төгрөгөөр нэмэгдэж, эцсийн үлдэгдэл 4.4 тэрбум төгрөг боллоо.
- Тайлант оны 4 дүгээр улирлын байдлаар төлбөрийн чадварын зохистой харьцаа нь 131.03 хувь байгаа нь Даатгалын багц дүрэм”-ийн хоёрдугаар хавсралт болох “Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ын 2.18-т “Даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцаа нь 110 хувь буюу түүнээс илүү байвал зохино” гэж заасан шалгуур үзүүлэлтийг хангаж байна.
- Сангийн сайдын 2020 оны 95 дугаар тушаалаар Үндэсний давхар даатгал ХК-ийн 2019 оны жилийн эцсийн аудитлагдсан тайлангийн хуримтлагдсан ашгаас

4,500,000,000 /дөрвөн тэрбум таван зуун сая/ төгрөгөөр компанийн дүрмийн санг нэмэгдүүлсэн.

- Төсвийн орлогын төлөвлөгөө 0.7 хувиар давж биелсэн ба төсвийн зардал батлагдсан төлөвлөгөөнөөс 24.96 хувиар хэмнэгдсэний үр дүнд 3.1 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Б. Цаашид компанийн стратеги төлөвлөгөө, зорилтыг бүрэн хэрэгжүүлж ажиллахын тулд гарах эрсдэлүүдийг үнэн зөв тооцоолж, дараах зорилгуудыг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй байна. Үүнд:

- Монгол Улсад ирэх онуудад түүхий эдийн уналт, гадаадын шууд хөрөнгө оруулалт буурснаар уул уурхайн салбарын өсөлт саарах, түүнийгээ дагаад уул уурхайг түшиглэсэн бусад салбартаа сөргөөр нөлөөлөх, мөн валютын орох урсгал нь гарах урсгалаас бага байх нь төгрөгийн эсрэг ам.долларын ханш чангарах зэрэг эрсдэлүүд гарч болзошгүй байгаа тул компанид сөргөөр нөлөөлөх эрсдэлийг багасгах;
- 2021 онд компанийн хөрөнгө оруулалтыг оновчтой, үр дүнтэй зохион байгуулж, сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх, шинэ болон хэрэгжүүлж буй даатгалын бүтээгдэхүүний учирч болзошгүй эрсдэлийг шинжилж, даатгалын хэлбэрийн нөөц санг чадавхжуулах;
- Компанийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор эдийн засаг, бизнесийн орчны судалгааг үр дүнтэй боловсруулах, нийт эрсдэлийг илрүүлж мэдээлэл цуглуулах, ажилтнуудын бүтээмжийг нэмэгдүүлэх;
- Олон улсын давхар даатгалын зах зээлд үйл ажиллагаагаа өргөжүүлэх;
- Ажилтнуудыг чадавхжуулах зорилгоор гадаад дотоодын сургалтуудад үе шаттай хамруулах, олон улсын давхар даатгалын компаниудад туршлага судлах арга хэмжээнд хамруулах;

-----oOo-----

ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ ХК
14251, Монгол Улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, 5 дугаар хороолол,
Чингисийн өргөн чөлөө-10Б байр,
“Бизнес тауэр”, 20 давхар
Э-шуудан: info@mongolianre.mn
Вэб: www.mongolianre.mn
Утас: 75770002